



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 41

Мандалговь

Хөрөнгө дахин үнэлж худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3 дах заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 16,499,700 /арван зургаан сая дөрвөн зуун ерэн есөн мянга долоон зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 5,607,100 /таван сая зургаан зуун долоон мянга нэг зуу/ үлдэгдэл өртөгтэй Халуун усны барилгыг акталж устгах, 19,130,800 /арван есөн сая нэг зуун гучин мянга найман зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 5,174,900 /таван сая нэг зуун далан дөрвөн мянга есөн зуу/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Зочид буудлын барилгыг дуудлага худалдаагаар худалдах доод үнийг 50 хувиар буулган хавсралтын дагуу худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

3. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 сарын 06—ны өдрийн “Хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах, балансаас баланст шилжүүлэх, акталж устгах зөвшөөрөл олгох тухай” 238 дугаар тогтоолын хавсралт 2-ыг хүчингүй болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ

0100083

Аймгийн ИТХТ-ийн 20. Боньд сарын
О. Ледрийн /р/ тогтоолын хавсралт

Худалдах хөрөнгийн жагсаалт

№	Барилга байгууламжын нэр	Ашиглалданд орсон огноо	Балансын үнэ	Үлдэгдэл өртөг	Хуучин үнэ	Худалдах үнийн доод хязгаар
1	Зочид буудал	1969	19,130,800	5,174,900	5,174,900	2,587,450
	Нийт дүн		19,130,800	5,174,900	5,174,900	2,587,450